

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай
хууль /шинэчилсэн найруулга/-д
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл болон дагалдах бусад хууль
тогтоомжийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг батлан 1994 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Энэ хугацаанд уг хуульд 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.” гэж өөрчлөн найруулсны дагуу өнөөгийн хот, тосгоны эрх зүйн байдалтай холбоотой харилцааг зохицуулж буй хуулийг шинэчлэн батлах үндэслэл бүрдсэн байна.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдох арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 4.3.4-д “шинэчлэн боловсруулсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудад салбарын бусад хууль тогтоомжийг нийцүүлэх” гэж, 4.3.4.1-д “Хот, тосгоны эрх зүйн үндсийг тодорхой болгож, тэдгээрийн өөрийн удирдлага, өмчийн болон төсвийн зохицуулалтыг нарийвчлан тусгах;” гэж, “Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг зохицуулах” гэж тус тус заасны хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 8 бүлэг, 54 зүйлтэй бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах нийтлэг журам, хотын зэрэглэл тогтоох шалгуур, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулах бөгөөд уг хуулийг дагаж мөрдөхөд тодорхой хугацаа шаардлагатай байсан тул 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр хуульд заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын

тухай, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолыг тус тус баталж, Дархан, Эрдэнэт, Зуунмод, Хархорум, Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 6 хот, орон нутгийн зэрэглэлтэй 43 хот (үүнээс 14 нь нийслэлд), дагуул 4 (үүнээс 3 нь нийслэлд) хотыг байгуулсан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, тэдгээрээс нэр дэвшүүлж томилогдсон Засаг дарга нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл харьяалах хотын Зөвлөл, Захирагчийн хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Мөн “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолын 11 дэх заалтаар хот шинээр байгуулсантай холбогдуулан улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч, хөрөнгө, төсөв, байгууллагын бүтэц, орон тоог чиг үүрэг нь шилжиж байгаа хотод хууль тогтоомжийн дагуу шилжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон.

Гэвч дээр дурдсан хотуудын эдэлбэр газрын хэмжээг тогтоох, чиг үүрэг нь шилжиж байгаа хотод өмч, хөрөнгө, төсөв, байгууллагын бүтэц, орон тоог шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутагтай зөвшилцөх болон бусад асуудлыг шийдвэрлэхэд багагүй хугацаа шаардагдахаар байна.

Иймд бодит хэрэгцээ, шаардлагын дагуу Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталж 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолд заасан дагаж мөрдөх хугацааг 1 жилээр тус тус хойшлуулахаар төсөлд тусган боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлаас байгуулсан хотууд бодитойгоор үйл ажиллагаагаа явуулах боломжтой болохын зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлт хэрэгжих юм.

---oOo---

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай
хууль /шинэчилсэн найруулга/-д
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл болон дагалдах бусад хууль
тогтоомжийн төсөл

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурал 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор баталж, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр хуульд заасан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолоор тодорхой чиг үүргийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх болон дагаж мөрдөхөөр заасан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, тэдгээрээс нэр дэвшүүлж томилогдсон Засаг дарга нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл харьяалах хотын Зөвлөл, Захирагчийн хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Дархан, Эрдэнэт, Зуунмод, Хархорум, Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 6 хот, орон нутгийн зэрэглэлтэй 43 хот (үүнээс 14 нь нийслэлд), дагуул 4 (үүнээс 3 нь нийслэлд) хотыг байгуулсан.

Мөн “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолын 11 дэх заалтаар хот шинээр байгуулсантай холбогдуулан улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч, хөрөнгө, төсөв, байгууллагын бүтэц, орон тоог чиг үүрэг нь шилжиж байгаа хотод хууль тогтоомжийн дагуу шилжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон.

Гэвч дээр дурдсан хотуудын эдэлбэр газрын хэмжээг тогтоох, чиг үүрэг нь шилжиж байгаа хотод өмч, хөрөнгө, төсөв, байгууллагын бүтэц, орон тоог шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутагтай зөвшилцөх болон бусад асуудлыг шийдвэрлэхэд багагүй хугацаа шаардагдахаар байгаа тул уг бодит хэрэгцээ, шаардлагын дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолын дагаж мөрдөх хугацааг 1 жилээр тус тус хойшлуулахаар төсөлд тусган боловсрууллаа.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр цахим хуудаст байршуулж, олон нийтийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд хуулийн төсөлд холбогдох санал ирээгүй байна.

---oOo---